



МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО  
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991  
Affiliated to FINA, 1996  
Affiliated to AASF, 2000

2025 оны 03-р сарын 25-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

“Олон улсын тэмцээнд оролцох тамирчдын сонгон шалгаруулалтын журам”-д нэмэлт оруулах тухай

“Монголын усан спорт сонирхогчдын холбоо” төрийн бус байгууллага (“Холбоо” гэх)-ын Удирдах зөвлөлийн хурал нь Холбооны дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.7.4 заалтыг үндэслэн “Олон улсын тэмцээнд оролцох тамирчдын сонгон шалгаруулалтын журам”-д нэмэлт оруулах төслийг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. “Олон улсын тэмцээнд оролцох тамирчдын сонгон шалгаруулалтын журам”-д оруулах нэмэлтийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын хэрэгжилтыг хангаж ажиллахыг УЗ-ийн дэргэдэх “Дасгалжуулагчдын зөвлөл” болон ЕНБД М.Энхбаатар нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

П.БАТСАЙХАН





## Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо



# Дэлхийн аварга, Олон улсын тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах журам

2023 ОНЫ 11 САРЫН 17-НЫ  
ӨДРӨӨС ХҮЧИН ТӨГӨЛДӨР  
ҮЙЛЧИЛНЭ



## НЭГ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1.1 Монгол улсыг төлөөлөн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад Олон улсын тэмцээнд оролцох усан спортын тамирчдыг МУССХ-ны Удирдах зөвлөлийн баталсан энэхүү журмын хүрээнд Дасгалжуулагчдын зөвлөл сонгон шалгаруулна.

1.2 Сонгон шалгаруулалтад доорхи шаардлагыг хангасан тамирчид оролцох эрхтэй. Үүнд:

- Монгол улсын иргэн байх.
- МУССХ-ны гишүүн тамирчин, эсвэл гишүүн клубын харьяалалтай тамирчин байх.
- Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics) болон Монголын усан спорт сонирхогчдын холбооноос ямар нэг шийтгэл аваагүй тамирчин байх.

1.3 Үндэсний гадаад паспортын шаардлага.

Тамирчин нь хүчин төгөлдөр Монгол улсын Үндэсний гадаад паспорттай байх ёстой бөгөөд хүчинтэй хугацаа нь тухайн тэмцээний сүүлийн өдрөөс хойш дор хаяж 6 сараас багагүй байна.

## ХОЁР. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ХУГАЦАА

2.1 Тухайн олон улсын тэмцээний зааврын дагуу тогтоож өгсөн хугацааны дотор Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics) эсвэл түүний гишүүн холбоодын зохион байгуулсан албан ёсны тэмцээн уралдаанд оролцож үзүүлсэн амжилтыг сонгон шалгаруултанд ашиглана.

Жишээ нь: “Доха-2024 ДАШТ”-ны сонгон шалгаруулалтанд тус тэмцээний журмын дагуу 2022 оны 10 сарын 01-нээс 2023 оны 12 сарын 19-ний хооронд дээрхи шаардлагын дагуу зохион байгуулагдсан тэмцээнүүдэд оролцож тогтоосон тамирчдын хувийн амжилтыг сонгон шалгаруулалтанд ашиглана.

2.2 Тамирчин гадаадад бэлтгэлд хамрагдаж, суралцаж байгаа эсвэл оршин сууж байгаа тохиолдолд тогтоосон хугацаа дуусахаас өмнө тэмцээнд оролцсон хувийн цагийн амжилтаа Монголын усан спорт сонирхогчдын холбооны цахим шуудан болох [secretariat@mongoliaaquatics.mn](mailto:secretariat@mongoliaaquatics.mn) хаяг руу албан ёсны баталгааны хамт илгээнэ.

## ГУРАВ. ТАМИРЧНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

3.1 Тухайн олон улсын тэмцээн 50м бассейнд болох бол 50м бассейнд үзүүлсэн тамирчны хувийн амжилтыг, хэрэв 25м бассейнд болох бол 25м бассейнд үзүүлсэн тамирчны хувийн амжилтыг сонгон шалгаруулалтанд ашиглана.

3.2 Зохион байгуулагчдын зүгээс тогтоож өгсөн тоон хязгаарын дотор тамирчид чөлөөтэй оролцох боломжтой олон улсын тэмцээнд, нэг төрөл зайд тогтоосон тооноос олон тамирчин оролцох хүсэлтээ ирүүлсэн бол тамирчдыг тухайн төрөл зайд үзүүлсэн амжилтаар нь эрэмбэлж сонголтыг хийнэ.



3.3 Заавал биелүүлсэн байх цагийн шаардлага бүхий тэмцээний хувьд тухайн тэмцээний шалгуур цагийн үзүүлэлтийг биелүүлсэн тамирчдыг сонгож тэмцээнд оролцуулна.

Жишээ нь: Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчид тухайн тэмцээний цагийн шалгуур үзүүлэлт болох А эсвэл В стандарт цагийг биелүүлсэн байна.

3.4 Тухайн тэмцээний цагийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тус тэмцээний В цагтай хамгийн ойр цагийн амжилт үзүүлсэн тамирчныг сонгож тэмцээнд оролцуулна.

3.5 Тухайн олон улсын тэмцээний В стандарт цагтай хамгийн ойр уралдсан тамирчдыг тогтоохдоо доорхи загварчлалыг ашиглана.

- Тухайн тэмцээний В стандарт цагийг хамгийн сүүлд зарлагдсан харгалзах LCM эсвэл SCM World Aquatics Points оноонд шилжүүлнэ (P1).
- Тамирчны үзүүлсэн цагийг хамгийн сүүлд зарлагдсан харгалзах LCM эсвэл SCM World Aquatics Points оноонд шилжүүлнэ (P2).
- Дээрхи 2 онооны зөрүү хамгийн бага тамирчдыг зай төрөл харгалзахгүй эрэмбэлж эрэмбийн эхнээс тогтоосон тоон хязгаарт нийцүүлсэн тамирчныг сонгон шалгаруулна (P0).
- Онооны зөрүүг тооцох томьёо  
 $P0 = P1 - P2$

#### ДӨРӨВ. КЛУБ, ТАМИРЧНЫ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

4.1. Холбооны шугамаар мэдүүлэг, бүртгэлийн ажил нь хийгдсэн олон улсын тэмцээнд гишүүн клуб, байгууллагууд Монгол улсыг төлөөлөн нэг багийн зохион байгуулалттай оролцоно.

4.2. Холбооны шугамаар мэдүүлэг, бүртгэлийн ажил нь хийгдээгүй, клуб, байгууллага, сургуулиудын дунд зохион байгуулагдаж буй олон улсын тэмцээнд оролцож байгаа холбооны гишүүн клуб, байгууллага нь энэхүү журмын 4.1 заасан шаардлагаас чөлөөлөгдөнө.

4.3. Монгол улсыг төлөөлөн олон улсын тэмцээнд оролцож байгаа багийн гишүүд доорхи үүргийг хүлээнэ.

4.3.1. Холбооны гүйцэтгэх удирдлагын баталсан Удирдамжийн дагуу, багийн ахлагчийн удирдлага доор тэмцээнд оролцох. Багийн ахлагч нь тухайн тэмцээнд оролцож буй холбооны Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч эсвэл ЕНБД байх бөгөөд аль ч байхгүй тохиолдолд холбооноос багийн ахлагчийг томилно.

4.3.2. Багийн гишүүд хувийн гараандаа оролцохоос гадна буухиа төрөлд оролцох үүрэг хүлээнэ. Буухиа багийн тамирчдын ямар төрөлд оролцох шийдвэрийг багийн амжилтад хамгийн ашигтай цагийн хувилбараар тооцож багийн ахлагч гаргана.

4.3.3. Буухиа багийн уралдаан нь багийн аль нэг гишүүний тухайн өдрийн хувийн гарааны амжилтанд сөргөөр нөлөөлөхөөр байвал багийн ахлагч 4.3.2. заалтын шаардлагаас чөлөөлөх үндэслэл болно.

4.3.4. Багийн нэгдсэн хувцсыг өмсөж тэмцээний үйл ажиллагаанд оролцоно.

4.3.5. Ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, өндөр сахилга бат, хариуцлагатайгаар өөрийн бүхий л ур чадварыг дайчлан оролцох.

4.4. Зохион байгуулагчдын зүгээс дасгалжуулагчдын тоонд хязгаарлалт тогтоосон бол



тухайн тэмцээнд оролцож буй тамирчдын тоогоор нь эрэмбэлэн клубуудын дасгалжуулагчдыг хуваарьлана.

## ТАВ. САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ХАРИУЦЛАГА

5.1 Олон улсын холбоо болон холбооноос олгож байгаа санхүүгийн дэмжлэг (нислэгийн тийз болон бусад холбогдох зардал)-ийг баталсан төсвийн хүрээнд ЕНБД хариуцан тамирчин, дасгалжуулагчид бэлэн бусаар зарцуулна.

5.2. Гадаад улсад бэлтгэл сургуулилтаа хийдэг тамирчны дэмжлэгийн хэмжээ Монгол улсад байгаа тамирчинд олгож буй дэмжлэгийн хэмжээнээс хэтрэхгүй байна. Хэрэв дэмжлэгийн дүн Монгол улсад байгаа тамирчинд үзүүлж буй хэмжээнээс бага байхаар бол зөрүүг тамирчинд олгох үүргийг хүлээхгүй.

5.3 Дасгалжуулагчдад олгох дэмжлэгийг тухайн тэмцээнд оролцож буй тамирчдынх нь тоотой хувь тэнцүүлэх зарчмаар тооцоолон олгоно.

5.4 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 4-өөс олон тамирчин оролцох боломжтой болсон тохиолдолд (3 тамирчин А болон В стандарт цагийг биелүүлсэн) стандарт цагийн болзол биелүүлсэн тамирчид болон биелүүлээгүй тамирчдад олгох дэмжлэгийг 2:1 харьцаагаар тооцоолон олгоно.

5.5. Холбоо нь тамирчид дасгалжуулагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор тэмцээний бүртгэлийн барьцаа хураамжийг авч болох бөгөөд тамирчин, дасгалжуулагч тэмцээнд оролцоогүй бол барьцааг холбооны мэдэлд үлдээх бөгөөд тэмцээний үеэр ямар нэг санхүүгийн хохирол учруулсан бол барьцаа төлбөрөөс нь суутган авна. Бусад тохиолдолд барьцаа төлбөрийг тэмцээний дараа тамирчин, дасгалжуулагчийн дансанд буцаан шилжүүлнэ.



“DOHA-2024 ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”-ИЙ  
P0 ОНООГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

World Aquatics Championships - Doha 2024 тэмцээний А, В стандарт цагууд болон түүнд харгалзах World Aquatics Point Scoring 2023 оноонууд

WOMEN				MEN				
W-"B"	Points	W-"A"	Points		M-"A"	Points	M-"B"	Points
25.95	759	25.04	844	50m Freestyle	22.12	844	22.89	762
56.15	781	54.25	866	100m Freestyle	48.51	901	50.21	813
2.02.81	779	1.58.66	863	200m Freestyle	1.47.06	865	1.50.81	780
4.19.34	758	4.10.57	840	400m Freestyle	3.48.15	898	3.56.14	810
8.56.03	740	8.37.90	821	800m Freestyle	7.53.11	873	8.09.67	788
17.04.20	726	16.29.57	805	1500m Freestyle	15.04.64	893	15.36.30	806
29.21	788	28.22	874	50m Backstroke	25.16	836	26.04	755
1.02.71	769	1.00.59	853	100m Backstroke	54.03	871	55.92	786
2.15.67	752	2.11.08	834	200m Backstroke	1.58.07	852	2.02.20	772
32.11	760	31.02	842	50m Breaststroke	27.33	856	28.29	772
1.09.71	779	1.07.35	863	100m Breaststroke	59.75	863	1.01.84	778
2.31.02	779	2.25.91	864	200m Breaststroke	2.10.32	903	2.14.88	815
27.24	721	26.32	799	50m Butterfly	23.53	847	24.35	765
1.00.37	776	58.33	861	100m Butterfly	51.96	862	53.78	777
2.13.73	756	2.09.21	838	200m Butterfly	1.56.71	845	2.00.79	763
2.17.63	770	2.12.98	853	200m Individual	1.59.53	868	2.03.71	783
4.52.97	752	4.43.06	834	400m Individual	4.17.48	850	4.26.49	766
3.42.20				4*100m Freestyle	3.15.80			
8.01.80				4*200m Freestyle	7.14.06			
4.02.26				4*100m Medley	3.35.86			

World Aquatics Point Scoring 2023 ашиглана.

- DOHA-2024 Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн 50м бассейнд зохиогдох тул LCM World Aquatics Point Scoring 2023 ашиглана.
- Long course (LCM) буюу 50 метрийн бассейны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний А, В стандарт цагууд тэмцээн тус бүрээр шинээр зарлагддаг бөгөөд тухайн тэмцээндээ хүчинтэй байдаг.

<https://www.worldaquatics.com/competitions/2969/world-aquatics-championships-doha-2024/info>

- World Aquatics Point Scoring нь жил бүр шинэчлэгдэх боломжтой бөгөөд World aquatics-ийн албан ёсны вэб хуудас дээр нийтлэгддэг.

<https://www.worldaquatics.com/swimming/points>

- Томъёоны гаргалгаа:

P0 - Онооны зөрүү (Point)  $P0 = P1 - P2$

P1 - Тухайн зай төрлийн “B” стандарт цагт харгалзах LCM “World Aquatics Point” оноо

P2 - Тамирчны сэлсэн зай төрлийн цагт харгалзах LCM “World Aquatics Point” оноо